



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/78

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож,
захиалагчийн төлөөлөгч томилж,
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дүгээр зүйлийн 30.1, 48 дугаар зүйлийн 48.2.6, 46.2.7, 48.2.9, Засгийн газрын 2023 оны “Журам батлах тухай” 278 дугаар тогтоол, Сангийн сайдын 2023 оны “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг батлах тухай” А/258 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны “Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай” А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хөрөнгө оруулалтаар санхүүжихээр батлагдсан Ахмад настны чийрэгжүүлэлтийн гадна талбайн тоног төхөөрөмж худалдан авах /Мөрөн сум, 7-р баг/ төсөл арга хэмжээний гүйцэтгэгч сонгох ХӨАХААГ/20240202039 дугаартай тендерт 29,810,000 (Хорин есөн сая найман зуун арван мянган) төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Кибержаал” ХХК -ийн тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. “Кибержаал” ХХК-тай гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, нийлүүлэх барааны чанар байдал, гэрээний нөхцөлүүдийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий “Захиалагчийн төлөөлөгч”-өөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Батбилгүүн)-г томилж, бараа, үйлчилгээ хүлээн авах, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Захиалагчийн төлөөлөгч:

Б.Батбилгүүн -

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

Н.Алтанчимэг -

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын
хөрөнгийн бүртгэл мэдээлэл хариуцсан
мэргэжилтэн)

Ш.Дарьжав -

(“Кибержаал” ХХК-ийн захирал)

Д.Лхагвасүрэн –

(аймгийн Иргэдийн хурлын төлөөлөгч)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

М.Даваадулам (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн
хамгааллын бодлого, үйл ажиллагааг зохион
байгуулах ахлах мэргэжилтэн)

6712010275

3. Ахмад настны чийрэгжүүлэлтийн гадна талбайн тоног төхөөрөмж худалдан авах /Мөрөн сум, 7-р баг/гүйцэтгэгч сонгох гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, гэрээний хэрэгжилтийг хангах, барааг (үйлчилгээг) хүлээн авах, гэрээг дүгнэх, санхүүжилтийн гүйцэтгэл баталгаажуулах, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн тухай ажлын үр дүнг тайлагнах, тайланг хавтаст хэрэг болгон орон нутгийн архивд шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг захиалагчийн төлөөлөгч (Б.Батбилгүүн)-д, захиалагч, тендерт оролцогч (тухайн тендерт оролцсон нийт оролцогч)-ийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээ дүгнэсэн акт, бараа (үйлчилгээ) хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг хуульд заасан бусад баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хавтаст хэрэг болгон орон нутгийн архивд шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Төмөр)-д тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ